

Жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 1/		
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргаагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.		
Тайлагнах хугацаа	2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
Үнэт цаас гаргаагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Компанийн нэр: Айтүүлс ХК УБГД: 9010001141 Үнэт цаасны код: 543 Утас: 75755585 Имэйл: info@itools.mn , secretary@itools.mn Фэйсбүүк: Айтүүлс ХК	
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж	
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Мэдээллийн технологи, харилцаа холбоо /Дата төвийн үйлчилгээ/	
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	Юнистар аудит ХХК	
Үнэт цаас гаргаагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	34,452,124	
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Ахлах нягтлан бодогч: Б.Өнөрбадрах Бизнес хариуцсан захирал: Д.Жигжид ТУЗ-ийн н/б дарга: Г.Янжинлхам Гүйцэтгэх захирал: Ч.Мөнхжаргал	
1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/	
	Санхүүгийн байдлын үзүүлэлт	2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Нэгдүгээр хавсралтаар хүргүүлэв.
	Орлогын тайлан	
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	

	Мөнгөн гүйлгээний тайлан	
1.1.	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт	
	Аудитын дүгнэлтийг хавсаргав.	
1.2.	Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/	
	Аудитын дүгнэлтийг хавсаргав.	
2.	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл	
2.1.	Үйл ажиллагааны Үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Цэвэр ашгийн хувь 13.1% Өөрийн хөрөнгийн өгөөж 14.5% Нийт хөрөнгийн өгөөж 13.2% Нэгж хувьцаанд ногдох ашиг 21.56
2.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Эргэлтийн харьцаа 4.72 Түргэн хөрвөх чадварын харьцаа 4.40
2.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	Хавсралтаар хүргүүлэв.
2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Санхүүгийн байдлын тайлангаас гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй.
2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны	Тайлант хугацаанд шинээр зээл аваагүй болно.


	<i>талаарх мэдээлэл;</i>	
3.	<i>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</i>	
	Урт хугацаат, найдваргүй авлагыг барагдуулах арга хэмжээ авах тухай – “Айтүүлс” ХК-ийн санхүүгийн тайлан балансад 2016 оноос хойш бүртгэгдсэн, санхүүгийн болон бусад нотлох баримт хангалтгүй, 8-10 жилийн насжилттай урт хугацааны авлагыг барагдуулах арга хэмжээний хүрээнд дараах шийдвэрийг гаргасан болно. Үйл ажиллагаа нь зогссон 3 компани дээр үүссэн уг авлагыг жил бүр санхүүгийн тайланд аудит хийсэн хөндлөнгийн аудитын байгууллагаас найдваргүй авлагад бүртгэх, найдваргүй авлагын сан үүсгэх, хасагдуулах арга хэмжээ авах тухай зөвлөмжийг өгдөг. Энэхүү зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлэх талаар мэргэжлийн хууль зүйн байгууллагаас зөвлөгөө авсны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлэсэн. Шийдвэр: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 25/015 дугаар тогтоолоор нэр бүхий 3 компанид холбогдох нийт 349,312,044.88 (гурван зуун дөчин есөн сая гурван зуун арван хоёр мянга дөчин дөрвөн төгрөг наян найман мөнгө) төгрөгийн авлагыг найдваргүй авлагад тооцож, санхүүгийн тайлан балансаас хасахаар шийдвэрлэсэн болно.	
4.	<i>Цалин урамшууллын мэдээлэл</i>	
	ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдэд 2025 оны ХЭЭХ-аар баталсан төсвийн дагуу цалин урамшуулал олгосон	
5.	<i>Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл</i>	
	Компани нь ХЭЭХ-ыг 4-р сарын 25-ны өдөр танхимаар амжилттай зохион байгуулж, хурлын тайлан материалыг СЗХ болон МХБ-д хүргүүлсэн. Тус хурлаар ТУЗ-ийг дараах бүрэлдэхүүнтэй сонгосон бөгөөд ТУЗ нь дарга болон Хороодын гишүүдийн хуваарилалтыг хийсэн. Айтүүлс ХК-ийн ТУЗ-ийн гишүүд, хороод: 1. ТУЗ-ийн дарга Г.Хатанболд ТУЗ-ийн ердийн гишүүн А. Баттамир ТУЗ-ийн ердийн гишүүн П.Дэлгэрмаа ТУЗ-ийн ердийн гишүүн З.Төрболд ТУЗ-ийн ердийн гишүүн Ч.Мөнхжаргал ТУЗ-ийн ердийн гишүүн Д.Сарнайцэцэг ТУЗ-ийн хараат бус гишүүн Г.Гантуяа ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Жавхланбаяр ТУЗ-ийн хараат бус гишүүн О.Мөнхзул 2. 2025 онд компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь нийт 9 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулсан бөгөөд үүнээс 3 нь хараат бус, 6 нь ердийн гишүүн байв. Айтүүлс ХК-ийн ТУЗ нь компанийн стратеги, бодлого, хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалан ажиллав. ТУЗ нь тухайн онд нийт 6 удаа ээлжит болон ээлжит бус хурлыг зохион байгуулж, компанийн үйл ажиллагааны чухал асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд дараах 4 хороо тогтвортой үйл ажиллагаа явуулсан: • Нэр дэвшүүлэх хороо – ТУЗ-ийн гишүүдийн сонгон шалгаруулалт, үнэлгээ • Цалин урамшууллын хороо – Удирдлагын цалин, урамшууллын бодлого	

	- Аудит, мэдээллийн аюулгүй байдлын хороо – Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, мэдээллийн аюулгүй байдлын хяналт - Бизнес хөгжил, технологийн хороо – Шинэ бизнесийн боломж, технологийн шинэчлэл 3. <u>ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга</u> ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Г.Янжинлхам нь Компанийн засаглалын сургалтад сууж, гэрчилгээ авсан компанийн засаглалын чиглэлээр ажлын туршлагатай болно.
6.	<i>Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл</i>
	байхгүй
7.	<i>Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/</i>
	Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид өөрчлөлт ороогүй болно. 2025 оны 4 сарын 02-ны өдрийн байдлаар нийт 2233 хүн Айтүүлс ХК-ийн хувьцаа эзэмшиж байсан. Үүнээс дараах нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нар байна. Үүнд: - Стандарт инвестмент ҮЦК ХХК – 32,6 - Ай Си Ти групп ХК – 17,8 - AFC Umbrella FUND-AFC Asia Frontier – 15.6
8.	<i>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл</i>
	2025 онд татан төвлөрүүлсэн хөрөнгө байхгүй.
9.	<i>Ногдол ашгийн мэдээлэл</i>
	"Айтүүлс" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн №25/001 тоот тогтоолоор компанийн 2024 оны жилийн эцсийн цэвэр ашгийн 26.65% буюу 120,582,434.00 төгрөгийг нийт хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон олгохоор шийдвэрлэсэн байна. Нэгж хувьцаанд 3.5 төгрөгөөр тооцон ногдол ашгийг хуваарилсан. Ногдол ашгийг 2025 оны 04-р сарын 30-ны өдөр Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ТӨХХК-аар дамжуулж олгосон.
10.	<i>Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл</i>
Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:	

Овог, нэр: Ч. Мөнхжаргал

Албан тушаал: "Айтүүлс" ХК-ийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:
(Тамга/тэмдэг)



Овог, нэр: М.Энхжаргал

Албан тушаал: "Юнистар аудит" ХХК-ийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:
(Тамга/тэмдэг)



Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо: 2026 оны 4 сарын 30-ны өдөр

Овог, нэр: Г.Янжинлхам

Албан тушаал: Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг:
(Тамга/тэмдэг)

G. Yanjinhkhaim